



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022-253-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Анхбаяр, Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Ankhubayaro@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт.....	21
4.1 Залруулсан алдаа: Аудитын явцад дараах алдааг залруулав. Үүнд:	21
4.2 Албан шаардлага	21
4.3 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОК	Аймгийн онцгой комисс
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөх хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СА 2022/253-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ДАРГА Г.ГАЛБАДРАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,451,866,417.86	1,898,127,047.04
33	АВЛАГА	72,989,678.30	34,226,959.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,242,788.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	42,076,256.30	34,226,959.00
335	Бусад авлага	29,670,634.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	29,670,634.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	934,432.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	934,432.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,377,942,307.56	1,863,900,088.04
351	Түүхий эд материал	473,411,740.74	680,149,090.74
35110	Тусгай зориулалттай материал	472,798,263.74	679,375,940.74
35130	Эм боох материал	613,477.00	773,150.00
354	Хангамжийн материал	903,046,066.82	1,181,266,497.30
35410	Бичиг хэргийн материал	2,417,845.00	3,714,395.00
35420	Аж ахуйн материал	6,878,800.00	13,119,360.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,874,500.00	25,847,000.00
35440	Түлш, шатах тослох материал	27,549,505.00	67,571,115.80
35460	Хүнсний материал	4,828,360.00	3,783,902.01
35470	Бусад хангамжийн материал	849,497,056.82	1,067,230,724.49
35600	Мал амьтад	1,484,500.00	2,484,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,155,728,136.83	10,060,446,715.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,155,728,136.83	10,060,446,715.67
392	Биет хөрөнгө	8,458,868,136.83	9,352,988,715.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,637,695,600.15	6,116,176,247.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-457,728,066.68	-837,619,016.23
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,979,407,605.08	7,683,082,182.08
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,097,643,851.24	-3,905,233,814.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,045,673,015.75	2,003,099,874.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,678,825,403.41	-1,749,000,476.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160,970,542.12	160,135,815.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-143,056,304.94	-134,637,252.14
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	16,861,700.00	15,190,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-4,486,700.00	-5,785,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,031,964.00	26,644,050.10
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,031,964.00	-19,063,894.41
393	Биет бус хөрөнгө	696,860,000.00	707,458,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	700,095,000.00	707,458,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,235,000.00	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,607,594,554.69	11,958,573,762.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,805,118.00	33,826,809.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,805,118.00	33,826,809.00
413	Өглөг	29,805,118.00	33,826,809.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	819,114.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	653,432.00	00.00

4136	Бусад өглөг	28,332,572.00	33,826,809.00
41361	Байгууллагад төлөх өглөг	23,238,700.00	33,826,809.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,093,872.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,577,789,436.69	11,924,746,953.71
51	Засгийн газрын хувь оролцоо	10,577,789,436.69	11,924,746,953.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,892,403,369.33	1,892,403,369.33
51101	Өмч:- төрийн	1,892,403,369.33	1,892,403,369.33
512	Хуримтлагдсан үр дүн	2,657,693,367.65	3,832,986,100.71
51210	Өмнөх үеийн үр дүн	2,657,693,367.65	2,475,650,378.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,357,335,722.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,027,692,699.71	6,199,357,483.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,607,594,554.69	11,958,573,762.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,441,280,299.00	7,273,616,093.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,756,804,715.70	2,724,056,801.22
120	Нийтлэг татварын бус орлого	2,756,804,715.70	2,724,056,801.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,756,804,715.70	2,724,023,751.22
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,756,804,715.70	38,776,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	2,015,723,316.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	00.00	669,524,434.94
120009	Бусад орлого	00.00	33,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,684,475,583.30	4,549,559,292.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,748,473,800.00	3,882,525,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,748,473,800.00	3,882,525,000.00
1311	санхүүжилтийн орлого	936,001,783.30	667,034,292.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	313,671,958.00	3,120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,991,906.00	193,140,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	410,952,919.30	386,406,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,385,000.00	84,367,101.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,278,984,862.84	5,835,974,321.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,278,984,862.84	5,835,974,321.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,055,973,684.84	5,811,548,617.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,952,391,371.00	3,043,538,290.00
210101	Үндсэн цалин	1,857,271,045.00	1,841,610,231.00
210102	Нэмэгдэл	1,041,012,326.00	1,142,064,559.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,108,000.00	59,863,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,192,705.00	90,039,064.00
210201	Тэтгэврийн даатгал	21,529,626.00	24,150,119.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,532,897.00	2,685,039.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,009,518.00	2,117,791.00

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	487,213.00	511,197.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,633,451.00	60,574,918.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	223,090,731.00	274,079,987.00
210301	Гэрэл, цахилгаан	41,535,799.00	48,820,564.00
210302	Түлш, халаалт	157,354,389.00	185,770,687.00
210303	Цэвэр, бохир ус	24,200,543.00	39,488,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	259,553,101.60	212,963,243.17
210401	Бичиг хэрэг	3,370,050.00	8,050,700.00
210402	Тээвэр, шатахуун	201,246,757.60	134,867,731.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,405,199.00	4,074,085.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,818,561.00	19,652,297.00
210408	Бараа материал акталсны зардал	42,712,534.00	46,318,429.97
2105	Нормативт зардал	183,425,437.00	170,631,215.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,412,500.00	2,029,127.00
210502	Хоол, хүнс	181,012,937.00	168,602,088.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,252,278.20	96,801,690.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,100,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,496,716.10	00.00
210604	Урсгал засвар	34,655,562.10	96,801,690.00
2107	Томилолт, зочны зардал	193,768,800.00	364,353,600.00
210702	Дотоод албан томилолт	190,183,500.00	364,096,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,585,300.00	257,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,841,330.00	127,565,803.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,800,000.00	119,505,670.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,933,490.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,264,396.00	2,210,547.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,040,853.00	3,131,629.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	589,000.00	1,464,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,947,010.00	633,500.00
210807	Газрын төлбөр	266,581.00	619,957.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,081,457,931.04	1,431,755,273.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	366,419,973.00	73,049,357.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	11,622,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	715,037,958.04	1,347,083,916.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,011,178.00	24,425,704.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	205,950,000.00	15,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	205,950,000.00	15,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,061,178.00	9,125,704.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,061,178.00	9,125,704.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,162,295,436.16	1,437,641,772.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	80,306,050.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	80,306,050.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-80,306,050.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,162,295,436.16	1,357,335,722.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,665,202,913.30	4,663,630,218.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,665,202,913.30	4,663,630,218.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,748,473,800.00	3,882,525,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,748,473,800.00	3,882,525,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	916,729,113.30	781,105,218.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	313,671,958.00	3,120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	190,719,236.00	245,862,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	410,952,919.30	386,406,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,385,000.00	145,716,027.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,629,302,913.30	4,427,551,039.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,629,302,913.30	4,427,551,039.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,373,915,479.00	4,360,698,376.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,951,633,600.00	3,043,114,616.00
210101	Үндсэн цалин	1,856,513,274.00	1,841,186,557.00
210102	Нэмэгдэл	1,041,012,326.00	1,142,064,559.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,108,000.00	59,863,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,226,305.00	89,972,414.00
210201	Тэтгэврийн даатгал	21,529,626.00	24,150,119.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,532,897.00	2,685,039.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,009,518.00	2,117,791.00
210204	Ажилгүйдлийн даатгал	487,213.00	511,197.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,667,051.00	60,508,268.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,733,799.00	280,972,391.00
210301	Гэрэл, цахилгаан	40,882,367.00	49,473,996.00
210302	Түлш, халаалт	135,650,889.00	192,009,659.00
210303	Цэвэр, бохир ус	24,200,543.00	39,488,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	182,443,909.00	151,074,767.00
210401	Бичиг хэрэг	4,616,400.00	7,819,750.00
210402	Тээвэр, шатахуун	162,164,160.00	129,558,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,370,199.00	4,012,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,293,150.00	9,683,747.00
2105	Нормативт зардал	250,037,860.00	192,169,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	86,030,360.00	14,545,800.00
210502	Хоол, хүнс	163,366,300.00	177,623,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	641,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,990,434.00	46,067,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,681,900.00	15,199,060.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,010,100.00	00.00
210604	Урсгал засвар	58,298,434.00	30,868,600.00
2107	Томилолт, зочны зардал	193,804,800.00	364,353,600.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	189,219,500.00	364,096,600.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,585,300.00	257,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,671,967.00	95,639,097.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,905,000.00	86,981,111.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,933,490.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,264,396.00	2,210,547.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,880,000.00	2,292,482.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	589,000.00	1,464,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,833,500.00	2,070,500.00
210807	Газрын төлбөр	266,581.00	619,957.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,372,805.00	97,334,581.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	276,737,617.00	85,712,581.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,635,188.00	11,622,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	255,387,434.30	66,852,663.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,650,000.00	23,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	197,650,000.00	23,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,737,434.30	43,352,663.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,737,434.30	43,352,663.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,900,000.00	236,079,179.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	35,900,000.00	236,079,179.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,900,000.00	236,079,179.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,900,000.00	236,079,179.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,900,000.00	236,079,179.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-35,900,000.00	-236,079,179.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,892,403,369.33	6,027,692,699.71	2,657,693,367.65	00.00	10,577,789,436.69
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,892,403,369.33	6,027,692,699.71	2,657,693,367.65	00.00	10,577,789,436.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-182,042,988.96	00.00	-182,042,988.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,892,403,369.33	6,027,692,699.71	2,475,650,378.69	00.00	10,395,746,447.73
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	171,664,783.96	00.00	00.00	171,664,783.96
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,357,335,722.02	00.00	1,357,335,722.02
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,892,403,369.33	6,199,357,483.67	3,832,986,100.71	00.00	11,924,746,953.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,882,525,000.00	3,873,399,296.00	-9,125,704.00	99.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,882,525,000.00	3,873,399,296.00	-9,125,704.00	99.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,873,122,000.00	3,863,999,296.00	-9,122,704.00	99.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,048,584,300.00	3,043,114,616.00	-5,469,684.00	99.82
210101	Үндсэн цалин	1,773,497,700.00	1,841,186,557.00	67,688,857.00	103.82
210102	Нэмэгдэл	1,215,636,600.00	1,142,064,559.00	-73,572,041.00	93.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,450,000.00	59,863,500.00	413,500.00	100.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,485,100.00	89,972,414.00	-512,686.00	99.43
210201	Тэтгэврийн даатгал	20,371,000.00	24,150,119.00	3,779,119.00	118.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,043,000.00	2,685,039.00	642,039.00	131.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,634,000.00	2,117,791.00	483,791.00	129.61
210204	Ажилгүйдлийн даатгал	409,200.00	511,197.00	101,997.00	124.93
210205	Эрүүл мэндийн даатгал	66,027,900.00	60,508,268.00	-5,519,632.00	91.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,978,900.00	280,972,391.00	-6,509.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	67,970,200.00	49,473,996.00	-18,496,204.00	72.79
210302	Түлш, халаалт	171,435,300.00	192,009,659.00	20,574,359.00	112.00
210303	Цэвэр, бохир ус	41,573,400.00	39,488,736.00	-2,084,664.00	94.99
2104	Хангамж, бараа материалын зардал	50,464,700.00	50,464,040.00	-660.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,865,000.00	2,865,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	41,300,000.00	41,299,340.00	-660.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,012,400.00	4,012,400.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,300.00	2,287,300.00	00.00	100.00
2105	Нормативт зардал	127,989,800.00	127,989,800.00	00.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,269,800.00	1,269,800.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	126,720,000.00	126,720,000.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	239,104,500.00	239,100,539.00	-3,961.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,701,500.00	4,699,060.00	-2,440.00	99.95
210604	Урсгал засвар	234,403,000.00	234,401,479.00	-1,521.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,404,000.00	2,404,000.00	00.00	100.00
210702	Дотоод албан томилолт	2,404,000.00	2,404,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,488,700.00	18,359,496.00	-3,129,204.00	85.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,953,700.00	9,939,010.00	-14,690.00	99.85
210803	Даатгалын үйлчилгээ	2,270,200.00	2,210,547.00	-59,653.00	97.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,780,000.00	2,292,482.00	-1,487,518.00	60.65
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,989,000.00	1,464,500.00	-1,524,500.00	49.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,833,500.00	1,833,000.00	-500.00	99.97
210807	Газрын төлбөр	662,300.00	619,957.00	-42,343.00	93.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11622000.00	11622000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,622,000.00	11,622,000.00	00.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9403000.00	9,400,000.00	-3000.00	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,403,000.00	9,400,000.00	-3,000.00	99.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,403,000.00	9,400,000.00	-3,000.00	99.97
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,882,525,000.00	3,882,525,000.00	00.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,882,525,000.00	3,882,525,000.00	00.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,882,525,000.00	3,882,525,000.00	00.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	746,878,259.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	746,878,259.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,778,259.30
2104	Хангамж, бараа материалын зардал	100,610,727.00
210401	Бичиг хэрэг	4,954,750.00
210402	Тээвэр, шатахуун	88,259,530.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,396,447.00
2105	Нормативт зардал	64,179,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,276,000.00
210502	Хоол, хүнс	50,903,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,174,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00
210604	Урсгал засвар	25,674,000.00
2107	Томилолт, зочны зардал	361,949,600.00
210702	Дотоод албан томилолт	361,692,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	257,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,151,901.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,042,101.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,109,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,712,581.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,712,581.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	781,105,218.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	781,105,218.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,120,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	245,862,360.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	386,406,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	145,716,027.30
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар /цаашид Онцгой байдлын газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төлбөрийн цахим баримт болон авлага, өглөгийн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр, Б.Наранцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ОБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус газар нь “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж зохион байгуулах, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд ажлын байрны нөхцөлийг сайжруулах, албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлж цэргийн алба, ажлын сахилга хариуцлагыг өндөржүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Онцгой байдлын албаны техник, багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн чанар, ашиглалтыг сайжруулах,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,

- Гамшгаас хамгаалах тухай хуульд /төрийн албан хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдэл/ нэмэлт өөрчлөлт орсон,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ОБЕГ-аас 2016 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд ОБЕГ-ын даргын баталсан удирдамжаар Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын газраас тус газрын үйл ажиллагаанд 5 чиглэлээр хяналт шалгалт явуулснаас гадна 2020 онд явуулсан иж бүрэн шалгалтын биелэлтийг шалгах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “**дунд**” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг **1.0** хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,278,984.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 52,789.8

мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **36.952.9** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

ОБГ-ын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,350,979.2 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	00.00	-
Авлага	73,924.1	34,226.9	-39,697.2
Бараа материал	1,377,942.3	1,863,900.1	485,957.8
Үндсэн хөрөнгө	9,155,728.1	10,060,446.7	904,718.6
Нийт хөрөнгө	10,607,594.5	11,958,573.7	1,350,979.2
Өр төлбөр	29,805.1	33,826.8	-4,021.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,577,789.4	11,924,746.9	1,346,957.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,607,594.5	11,958,573.7	1,350,979.2

Авлага дансны үлдэгдэл 39,697.2 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн 42,076.3 мянган төгрөгийн, бусад 31,847.8 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулж, Зам тээврийн яамнаас Улаанбаатар-Дархан чиглэлийн замын өргөтгөлийн шинэчлэлийн ажлын автозамын трасст орсон Баянгол сум дахь ОБХ-ийн гал унтраах аврах 40 дүгээр ангийн хашаа, зам талбай, харуулын байр, ногоон байгууламж, цамхгийг шилжүүлэн байршуулж, угсрах ажлын санхүүжилт 34,226.9 мянган төгрөг олгосныг татан төвлөрүүлж, авлагаар тусгаснаас шалтгаалсан байна.

Бараа материалын данс 1,863,900.1 мянган төгрөг болж 485,957.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 497,063.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ОБЕГ-аас 479,821.2 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан болон Дэлхийн зөн ОУБ-аас 24,302.9 мянган төгрөгийн сургалтын материал, УИХ-ын гишүүн Ч.Ундрамаас 10,452.0 мянган төгрөгийн нэг удаагийн халдвар хамгааллын хувцас, аймгийн ЗДТГ-аас 153,973.1 мянган төгрөгийн бараа материал, Магнай трейд, Ник ХХК-аас нийт 3,475.3 мянган төгрөгийн шатахууныг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаанд 556,505.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулан, ОБГ-ын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар 46,318.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж, АОК-ын шийдвэрийг үндэслэн 80,306.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансанд тайлант оны эцэст өмнөх оны үлдэгдлээс материаллаг хэмжээгээр өссөн тусгай зориулалтын материал, түлш, шатах тослох материалын данс байна. Энэ нь ОБГ-ын үндсэн үйл ажиллагаа болох гал, түймэр унтраах, аврах ажиллагааны өндөр өртөгтэй тусгай хэрэгслийн бараа материал болон гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор нөөцөлсөн шатахууны үлдэгдлээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 10,060,446.7 мянган төгрөг болж өмнөх оноос 904,718.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 236,079.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ОБЕГ-аас 1,737,933.8 мянган төгрөгийн гал унтраах зориулалтай тусгай тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, Дэлхийн зөн ОУБ-аас 15,233.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил болон Мандал сумын Засаг даргын 2021 оны А/54 дүгээр захирамжаар сумын ЗДТГ-аас 9,990.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг тус тус үнэ төлбөргүй авсан, Хүдэр сумын ЭМТ-өөс 275,374.6 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан болон ТӨБЗГ-ын 2021 оны 725 дугаар тогтоолоор 109,560.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,924,746.9 мянган төгрөг болж 1,346,957.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлогоос шалтгаалж хуримтлагдсан үр дүн өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 167,664.2 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 134,084.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн боловч үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 32,781.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 268,967.5 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 556,989.5 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,488,067.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг цалин, хөлс нэмэгдэл урамшууллыг 487,870.8 мянган төгрөг, хангамж, бараа материалыг 151,002.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 215,370.3 мянган төгрөгөөр, бусад зардлыг 166,816.3

мянган төгрөгөөр зэрэг нийт 1,021,060.3 мянган төгрөгөөр бууруулж, 3,467,006.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг 415,518.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж **3,882,525.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь эд хогшил, урсгал засварын зардлыг 239,104.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 53,100.0 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 41,300.0 мянган төгрөгөөр, цалин, хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 39,500.0 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 11,622.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 21,488.7 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 9,403.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 3,882,525.0 мянган төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 3,882,525.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд **3,873,399.3** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 9,125.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,873,399.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 5,469.7 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 512.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.7 мянган төгрөгөөр, эд хогшил, худалдан авах зардлыг 3.9 мянган төгрөгөөр, бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,129.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 3.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ОБЕГ-аас гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдад олгох томилолт болон ахмадын сангийн санхүүжилтийн нийт 386,406.8 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас хяналтын цэг байгуулах, үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх, АОК-ын шуурхай штабын үйл ажиллагааны санхүүжилтийн 245,862.4 мянган төгрөг, иргэн, ААНБ-аас өгсөн хандивын 3,120.0 мянган төгрөг, Сангийн яамнаас Баянгол сум дахь ОБХ-ийн гал унтраах аврах 40 дүгээр ангийн хашаа, зам талбай, харуулын байр, ногоон байгууламж, цамхгийг шилжүүлэн байршуулж, угсрах ажлын санхүүжилтийн 77,042.1 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 7,325.0

мянган төгрөг, урьд оны татаас санхүүжилтийн авлагын 42,076.3 мянган төгрөг, урд оны ойн хээрийн түймрийн урьдчилан сэргийлэх үлдэгдэл санхүүжилтийн 19,272.7 мянган төгрөг зэрэг нийт 781,105.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн нийт 619,314.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтад тус байгууллагын ажилчдын хувийн болон бусад аж ахуйн нэгжүүдийн давхардуулан шивсэн 81,421.2 мянган төгрөгийн худалдан авалт байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

2. Тус газрын нярав, нягтлан бодогчийн ажлын ачаалал хэт их, хүн хүчний дутагдалтай байдал зэргээс шалтгаалан санхүүгийн тайлан, бараа материалын тайлан, нэмэлт санхүүжилтийн дансны баримтуудыг тогтоосон хугацаанд эцэслэн ирүүлээгүйн улмаас цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдал үүсгэж, аудит хийхэд хүндрэл учруулж байна. Цаашид бүртгэл, санхүүгийн ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, орон тоог нэмэгдүүлэх замаар санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд гаргаж ирүүлж байх шаардлагатай байна.

3. Аудитын явцад түүвэр хийж үзэхэд ОБЕГ-ын даргын тушаалаар томилогдсон гэх тус газарт ажилладаггүй, харуулын ээлжийн томилгоонд бүртгэгдээгүй Э. Алтанхишигийг аврагч-тэсэлгээчин, Э.Эрин, О.Ууганбаатар нарыг аврагч-гал сөнөөгч, өндөр насны тэтгэвэрт гарсан М. Сүрэндондовыг хүндэтгэлийн өргөө болон ахмадын өргөө хариуцсан ажилтан зэрэг албан тушаалын орон тоонд тус тус цалинжуулж, нийт **33,494.0** мянган төгрөгийн цалин тооцож, олгосон байна. Цаашид тус байгууллагад ажил эрхэлдэггүй хүнд цалин олгож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг таслан зогсоох нь зүйтэй байна.

4. Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ОБЕГ-аас 2016 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Иймд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтад холбогдох хууль, эрхийн актын өөрчлөлтийг тусган, шинээр боловсруулж, мөрдөх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ОБГ-ын мэдээлбэл зохих 22 төрлийн 175 мэдээлэл байршуулахаас 154 мэдээллийг хугацаанд нь **21** мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,290.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,542.4 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	2,290.3	2	2,290.3	100.0
Албан шаардлага	1	2,542.4	1	2,542.4	100.0
Зөвлөмж	5	10,439.9	3	10,439.9	60.0
Нийт дүн	8	15,272.6	6	15,272.6	75.0

/мянган төгрөг/

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх, цэргийн албан хаагчийн хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсаны тэтгэмжийг тооцох дундаж цалинг буруу тооцсон зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан

АОК-ын зардлын тайланг бүрэн тулган баталгаажуулах боломжгүй байсан тул дараагийн аудитаар гүнзгийрүүлэн авч үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 679,409.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 31,142.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 16,493.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 631,774.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа: Аудитын явцад дараах алдааг залруулав. Үүнд:

- Авлага, өр төлбөрийн тооцооны дансаар дамжсан 20,000.0 мянган төгрөгийн шатахууныг бараа үйлчилгээний бусад зардлаар буруу бүртгэсэн,
- Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн зардлын эдийн засгийн ангиллыг буруу сонгож, санхүүгийн үр дүнг 11,142.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг тус тус залруулсан.

4.2 Албан шаардлага

4.2.1. ОБЕГ-ын даргын 2021 оны А/75 дугаар тушаалаар гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдад олгосон албан томилолт, урамшууллын зардлаас /нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан/ хэмнэгдсэн **6,720.0** мянган төгрөгийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр шатахууны зардалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.2.2. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр ОБГ-ын 2020 оны Б/134 дүгээр тушаалаар 2020 онд “Оны тэргүүний албан хаагч”, “Онцгой байдлын газрын даргын нэрэмжит шагнал”-аар шагнагдсан 14 албан хаагчид тайлант оны төсвөөс нийт **9,773.8** мянган төгрөгийн цалингийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3 дахь “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

1.1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэлтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд бүрэн тусгаагүй буюу аль хөрөнгөд хамаарах нь тодорхой бус байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл: Нягтлан бодох бүртгэлийн зарчим, 5.1.4: “Үнэн зөв” гэсэн зарчмыг зөрчсөн тулд үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө тус бүрд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандартыг баримтлан ажиллах.

1.2.1 Илрүүлэлт: Бараа материалыг зөв ангилж бүртгээгүйгээс нийт **30,405.6** мянган төгрөгийн урсгал засварын материалыг хангамжийн материалын дансаар дамжуулан зарцуулсан ба түлээ, нүүрсний нийт **92,925.0** мянган төгрөгийн зарцуулалтыг ажил гүйлгээ гарсан тухай бүр шаардах хуудсаар бус жилийн эцэст бөөн дүнгээр зарлагдсан байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 4.10, 2.1.4 гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул хөрөнгийн ангилал болон нэршлийг зөв бүртгэх, түлээ, нүүрсний зарцуулалтыг шаардах хуудас, бараа материалын зарцуулалтын тайлан зэрэг батлагдсан загвар баримтаар баталгаажуулж, ажил гүйлгээ гарсан тухай бүр хөтлөх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Төлбөрийн цахим баримттай холбоотой:

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 468,238.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд

зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой:

3.1 Илрүүлэлт: Татварын цахим системийн татварын тооцоололд цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын 6,743.8 мянган төгрөгийн, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 255.1 мянган төгрөгийн, улсын тэмдэгтийн хураамжийн 4,147.5 мянган төгрөгийн зэрэг нийт **11,146.5** мянган төгрөгийн илүү төлөлттэй тайлагнагдсан байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 2022 оны эхний хагас жилд багтаан тооцоо нийлж, татварын үлдэгдлийг тулган баталгаажуулах.

4. Анхан шатны баримттай холбоотой:

5.1 Илрүүлэлт: ОБЕГ-аас шатахууны картаар шилжүүлэн авсан 35,000.0 мянган төгрөгийн, Тэс петролиум ХХК-аас худалдан авсан 3,243.2 мянган төгрөгийн, АОК-ын 1,961.9 мянган төгрөгийн зэрэг нийт **40,205.1** мянган төгрөгийн шатахууныг гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй буюу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Онцгой байдлын газар	11	679,409.9	2	31,142.0	-	-	2	16,493.8	5	631,774.1

/мянган төгрөгөөр/